



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 1/34

Улаанбаатар хот

Хүн, малын гоц халдварт болон тарваган
тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.2, 35.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/948 дугаар захирамж, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/119 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгалийн голомтот тарваган тахал болон хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл эрчимжүүлэн ажилласугай.

2. Байгалийн голомтот хүн, мал амьтны гоц халдварт болон тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, бэлэн байдлыг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Эмч, эмнэлгийн ажилчдад даалгах нь:

3.1 Хүн, мал амьтны гоц халдварт өвчин, тарваган тахал өвчний халдвараас урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Мэдээлэл технологийн ажил хариуцсан ажилтан (Г.Гантуяа)-д

3.2 Эрүүл мэндийн сайдын 2017 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Тарваган тахал өвчний хариу арга хэмжээний заавар”-ыг ажилчдад танилцуулах, эмнэлэг дотор халдвар гарахаас урьдчилан сэргийлж, урсгалын зохион байгуулалтыг хийх, эмнэлгийн тусламж үйлчилгээ болон тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангаж ажиллахыг их эмч (Ч.Баасанноров)-д

3.3 Хамгаалах хувцас хэрэгсэл, эм тариа, урвалж оношлуур, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангаж ажиллахыг эм найруулагч (Д.Дашдулам)-д

3.4 Тарваган тахлын сэжигтэй тохиолдол бүртгэдсэн үед яаралтай дуудлагын багийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг хийж үүрэгжүүлэн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан (Г.Гантуяа)-д

3.5 Хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг оношлох, өвчтөнөөс лабораторийн сорьц авах, савлах, тээвэрлэх ажлыг зохион байгуулахыг лаборант (Н.Батцэцэг)-т

3.6 Халдвар хамгааллын хамгаалах хувцас хэрэглэл өмсөх, тайлах арга зүй, сэтгэл зүйн чиглэлээр эмч эмнэлгийн ажилчдыг дадлагаажуулах ажлыг Ахлах сувилагч (О.Удвал)-д

3.7 Хэрэгжүүлэх буй ажлын явцын тайланг 14 хоног тутамд пүрэв гаригийн 14:00 цагт, нэгдсэн тайланг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэст цаасан болон цахим хэлбэрээр (batarsuh2230@gmail.com) хүргүүлэн ажиллахыг статистикч (О.Удвал)-д

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн ажилтан (Гантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Х.ГАНБАТ

Багахангай Эрүүл мэндийн төвийн даргын
2024 оны 08 дүгээр сарын 23 -ны өдрийн
НЗН тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч

Их эмч

Ч.Баасанноров

Гишүүн

Их эмч

О.Номиндалай

Сувилагч

А.Ариунзаяа

Сувилагч

Х.Далайбаяр

Нарийн бичгийн дарга

Статистикч

О.Удвал